



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Түнэл сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** ХӨА-2022/92/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Хөвсгөл аймаг, Мөрөн сум  
2022 он

Хөвсгөл аймаг дахь Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: А. Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: [erdenebaatara@audit.gov.mn](mailto:erdenebaatara@audit.gov.mn)

Аудитын менежер: Э. Бат-Эрдэнэ

Утас: 99900662, Цахим хаяг: [Baterdenee@audit.gov.mn](mailto:Baterdenee@audit.gov.mn)

Ахлах аудитор: Д. Отгонбаяр

Утас: 89306788, Цахим хаяг: [otgonbayarde@audit.gov.mn](mailto:otgonbayarde@audit.gov.mn)

Ньюбаланс Аудит ХХК-ийн захирал Б. Лхагвадорж

Утас: 99101901 Цахим хаяг: [newbalance.lhagvaa@gmail.com](mailto:newbalance.lhagvaa@gmail.com)

Чанарын хяналтын менежер Д. Гэрэлчулуун

Утас: 99509636.Цахим хаяг: [d.gerlee98@gmail.com](mailto:d.gerlee98@gmail.com)

Аудиторын туслах: Т. Мөнхгэрэл, Холбогдох утас: 99011389

Цахим хаяг: [tumurmunkh08@gmail.com](mailto:tumurmunkh08@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлтийн хэлбэр.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	15
3.4 Материаллаг байдал.....	15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	18
3.8 Аудитын гол асуудал .....	18
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	18
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	19
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	20
4. Аудитын илрүүлэлт.....	20
4.1 Залруулсан алдаа.....	20
4.2 Төлбөрийн акт.....	20
4.3 Албан шаардлага.....	20
4.4 Зөвлөмж.....	21

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
СЯ	Сангийн яам
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2022.02.25 № 01/2022  
танай -ны № -Т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ТҮНЭЛ СУМЫН  
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН  
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Ж.БАЯРМАА  
ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Түнэл сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Түнэл сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЗБААТАР

**2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

(төгрөгөөр)

Хөвсгөл аймгийн Түнэл сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>131,502,660.54</u></b>	<b><u>157,879,265.27</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	00.00	00.00
31211	Төрийн сангийн харилцах	00.00	00.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	2,550,400.00	00.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	2,550,400.00	00.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	128,952,260.54	157,879,265.27
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	1,792,041.00	3,294,969.00
35130	Эм боох материал	1,792,041.00	3,294,969.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	127,160,219.54	154,584,296.27
35410	Бичиг хэргийн материал	192,000.00	685,054.00
35420	Аж ахуйн материал	119,392,860.50	131,368,942.23
35440	Түлш, шатах тослох материал	220,000.04	1,360,000.04
35450	Барилгын засварын материал	3,318,380.00	13,314,250.00
35460	Хүнсний материал	3,015,479.00	6,776,450.00
35470	Бусад хангамжийн материал	1,021,500.00	1,079,600.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>802,434,216.65</u></b>	<b><u>2,560,442,458.80</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	802,434,216.65	2,560,442,458.80
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	765,750,783.32	2,523,809,025.51
39201	Барилга, байгууламж, орон сууц	772,204,401.00	2,569,577,833.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-132,470,219.82	-206,964,481.62
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	192,400,273.74	226,338,780.24
39206	Хуримтлагдсан элэгдэл	-147,231,035.75	-148,153,497.54
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	120,202,654.99	128,235,422.66
39208	Хуримтлагдсан элэгдэл	-74,363,991.22	-74,522,600.56
39217	Ном	35,008,700.38	29,297,569.33
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	36,683,433.33	36,633,433.29
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,358,166.67	-1,408,166.71
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>933,936,877.19</u></b>	<b><u>2,718,321,724.07</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>933,936,877.19</u></b>	<b><u>2,718,321,724.07</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	933,936,877.19	2,718,321,724.07
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	-263,844,622.33	1,525,432,879.37
51210	Өмнөх үеийн үр дүн	-263,844,622.33	-261,502,367.51

Хөвсгөл аймгийн Түнэл сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

51220	Тайлант үеийн үр дүн	00.00	1,786,935,246.88
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	437,959,139.06	433,066,484.24
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>933,936,877.19</u></b>	<b><u>2,718,321,724.07</u></b>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

(Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>3,032,566,748.62</b>	<b>3,083,413,715.18</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,810,633,198.35</b>	<b>1,839,870,022.63</b>
120	Нийтлэг татварын бус орлого	1,810,633,198.35	1,839,870,022.63
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,810,423,198.35	1,839,870,022.63
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,810,423,198.35	1,839,870,022.63
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>171,509,800.00</b>	<b>240,073,792.55</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,050,423,750.27	1,003,469,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,340,400.00	12,848,592.55
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,340,400.00	12,288,592.55
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	560,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	171,719,800.00	227,225,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	171,719,800.00	227,225,200.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,295,160,155.74</b>	<b>1,296,478,468.30</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,295,160,155.74</b>	<b>1,296,478,468.30</b>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,168,624,844.20	1,245,836,838.75
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	760,773,334.73	768,709,235.00
210101	Үндсэн цалин	644,976,823.53	622,213,798.00
210102	Нэмэгдэл	51,381,999.00	98,685,341.00
210104	Урамшуулал	64,414,512.20	47,810,096.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	94,757,706.00	99,674,758.00
210201	Тэтгэврийн даатгал	64,551,401.00	69,044,110.13
210202	Тэтгэмжийн даатгал	7,594,284.00	7,703,469.59

Хөвсгөл аймгийн Түнэл сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210203	ҮОМШӨ-ний даатгал	6,075,425.00	6,162,775.71
210204	Ажилгүйдлийн даатгал	1,503,327.00	1,524,036.57
210205	Эрүүл мэндийн даатгал	15,033,269.00	15,240,366.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	175,885,128.00	202,865,458.00
210301	Гэрэл, цахилгаан	5,405,504.00	8,821,304.00
210302	Түлш, халаалт	169,133,624.00	193,445,714.00
210303	Цэвэр, бохир ус	1,346,000.00	598,440.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,031,280.00	19,416,489.93
210401	Бичиг хэрэг	2,340,000.00	423,000.00
210402	Тээвэр, шатахуун	3,808,180.00	2,629,500.00
210404	Ном, хэвлэл	300,000.00	13,386,569.93
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,343,100.00	2,977,420.00
2105	Нормативт зардал	28,827,242.00	43,397,049.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,048,916.00	839,850.00
210502	Хоол, хүнс	27,778,326.00	42,557,199.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,137,000.00	5,051,687.95
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	40,657.95
210604	Урсгал засвар	3,137,000.00	5,011,030.00
2107	Томилолт, зочны зардал	42,000.00	210,000.00
210702	Дотоод албан томилолт	42,000.00	210,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	600,000.00	3,187,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	100,000.00	2,587,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	600,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	94,571,153.47	103,325,160.87
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,872,350.00	6,548,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	92,698,803.47	96,776,660.87
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	126,535,311.54	50,641,629.55
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,384,700.00	30,921,300.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	14,384,700.00	30,921,300.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	98,097,139.54	12,532,487.55
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	98,097,139.54	12,532,487.55

2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	14,053,472.00	7,187,842.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,053,472.00	7,187,842.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>1,737,406,592.88</b>	<b>1,786,935,246.88</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>1,737,406,592.88</b>	<b>1,786,935,246.88</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(Төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>C01</b>	<b>2020 оны 1 дүгээр сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>723,384,760.46</b>	<b>141,919,914.80</b>	<b>-12,093,448.57</b>	<b>853,211,226.69</b>
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
<b>C03</b>	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>723,384,760.46</b>	<b>141,919,914.80</b>	<b>-12,093,448.57</b>	<b>853,211,226.69</b>
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-184,857,884.83	-184,857,884.83
<b>C08</b>	<b>2020 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>759,822,360.46</b>	<b>437,959,139.06</b>	<b>-263,844,622.33</b>	<b>933,936,877.19</b>
<b>D01</b>	<b>2021 оны 1 дүгээр сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>759,822,360.46</b>	<b>437,959,139.06</b>	<b>-263,844,622.33</b>	<b>933,936,877.19</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн	00.00	00.00	2,342,254.82	2,342,254.82

Хөвсгөл аймгийн Түнэл сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

	бодлогын өөрчлөлт				
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	759,822,360.46	437,959,139.06	-261,502,367.51	936,279,132.01
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-4,892,654.82	00.00	-4,892,654.82
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	1,786,935,246.88	1,786,935,246.88
D09	2021 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	759,822,360.46	433,066,484.24	1,525,432,879.37	2,718,321,724.07

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>1,222,143,550.27</u></b>	<b><u>1,243,543,692.55</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>210,000.00</b>	<b>00.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	210,000.00	00.00
120005	Түрээсийн орлого	210,000.00	00.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,221,933,550.27</b>	<b>1,243,543,692.55</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,050,423,750.27	1,003,469,900.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	2,340,400.00	12,848,592.55
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,340,400.00	12,288,592.55
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	560,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	171,719,800.00	227,225,200.00

Хөвсгөл аймгийн Түнэл сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	171,719,800.00	227,225,200.00
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	-2,550,400.00	00.00
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	-2,550,400.00	00.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>1,213,269,750.27</u></b>	<b><u>1,212,515,242.55</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,213,269,750.27</b>	<b>1,212,515,242.55</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,086,734,438.73</b>	<b>1,161,873,613.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	756,617,302.13	768,709,235.00
210101	Үндсэн цалин	632,669,043.04	557,728,318.00
210102	Нэмэгдэл	67,211,485.09	165,401,317.00
210104	Урамшуулал	56,736,774.00	45,579,600.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	98,913,738.60	99,674,758.00
210201	Тэтгэврийн даатгал	98,913,738.60	99,674,758.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	174,965,128.00	204,005,458.00
210301	Гэрэл, цахилгаан	5,405,504.00	8,821,304.00
210302	Түлш, халаалт	168,363,624.00	194,585,714.00
210303	Цэвэр, бохир ус	1,196,000.00	598,440.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	7,549,650.00	13,246,804.00
210401	Бичиг хэрэг	268,700.00	865,354.00
210402	Тээвэр, шатахуун	4,192,330.00	2,629,500.00
210404	Ном, хэвлэл	300,000.00	4,603,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	548,620.00	456,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,240,000.00	4,691,950.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	44,771,120.00	48,422,658.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,550,000.00	568,888.00
210502	Хоол, хүнс	28,162,200.00	46,318,170.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	15,058,920.00	1,535,600.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	00.00	17,349,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	280,000.00
210604	Урсгал засвар	00.00	17,069,900.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	42,000.00	210,000.00
210702	Дотоод албан томилолт	42,000.00	210,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	600,000.00	3,187,000.00

Хөвсгөл аймгийн Түнэл сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	100,000.00	2,587,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	600,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>3,275,500.00</b>	<b>7,067,800.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,275,500.00	7,067,800.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>126,535,311.54</b>	<b>50,641,629.55</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>14,384,700.00</b>	<b>30,921,300.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	14,384,700.00	30,921,300.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>98,097,139.54</b>	<b>12,532,487.55</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	98,097,139.54	12,532,487.55
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>14,053,472.00</b>	<b>7,187,842.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,053,472.00	7,187,842.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>8,873,800.00</u></b>	<b><u>31,028,450.00</u></b>
	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b><u>00.00</u></b>	<b><u>00.00</u></b>
<b>4</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>8,241,300.00</b>	<b>31,028,450.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>8,241,300.00</b>	<b>31,028,450.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>8,241,300.00</b>	<b>31,028,450.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	8,241,300.00	31,028,450.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>-8,241,300.00</u></b>	<b><u>-31,028,450.00</u></b>
	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b><u>00.00</u></b>	<b><u>00.00</u></b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b><u>00.00</u></b>	<b><u>00.00</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>632,500.00</b>	<b>00.00</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/төгрөгөөр/

	<b>Үзүүлэлт</b>	<b>Тайлант оны</b>
--	-----------------	--------------------

Хөвсгөл аймгийн Түнэл сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Эдийн засгийн ангилал		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,230,695,100.00	1,210,974,771.00	19,720,329.00	98.4
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,230,695,100.00	1,210,974,771.00	19,720,329.00	98.4
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,198,623,700.00	1,180,053,471.00	18,570,229.00	98.5
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	773,456,600.00	768,709,235.00	4,747,365.00	99.4
210101	Үндсэн цалин	551,754,600.00	557,728,318.00	-5,973,718.00	101.1
210102	Нэмэгдэл	175,702,000.00	165,401,317.00	10,300,683.00	94.1
210104	Урамшуулал	46,000,000.00	45,579,600.00	420,400.00	99.1
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	104,416,600.00	99,674,758.00	4,741,842.00	95.5
210201	Тэтгэврийн даатгал	73,478,300.00	99,674,758.00	-26,196,458.00	135.7
210202	Тэтгэмжийн даатгал	7,734,600.00	00.00	7,734,600.00	0.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,187,600.00	00.00	6,187,600.00	0.0
210204	Ажилгүйдлийн даатгал	1,546,900.00	00.00	1,546,900.00	0.0
210205	Эрүүл мэндийн даатгал	15,469,200.00	00.00	15,469,200.00	0.0
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	211,164,900.00	204,005,458.00	7,159,442.00	96.6
210301	Гэрэл, цахилгаан	9,000,000.00	8,821,304.00	178,696.00	98.0
210302	Түлш, халаалт	200,664,900.00	194,585,714.00	6,079,186.00	97.0
210303	Цэвэр, бохир ус	1,500,000.00	598,440.00	901,560.00	39.9
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	10,129,000.00	8,967,800.00	1,161,200.00	88.5
210401	Бичиг хэрэг	523,800.00	522,800.00	1,000.00	99.8
210402	Тээвэр, шатахуун	4,692,638.00	1,300,000.00	3,392,638.00	27.7
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	59,200.00	00.00	59,200.00	0.0
210404	Ном, хэвлэл	261,500.00	00.00	261,500.00	0.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон	550,000.00	456,600.00	93,400.00	83.0

Хөвсгөл аймгийн Түнэл сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

	мэрэгчдийн устгал, ариутгал				
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,041,862.00	6,688,400.00	-2,646,538.00	165.5
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	48,538,200.00	48,066,020.00	472,180.00	99.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	663,800.00	212,250.00	451,550.00	32.0
210502	Хоол, хүнс	46,338,800.00	46,318,170.00	20,630.00	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,535,600.00	1,535,600.00	0.00	100.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	43,665,300.00	43,558,900.00	106,400.00	99.8
210601	Багаж, техник, хэрэгсэл	17,435,000.00	17,357,000.00	78,000.00	99.6
210602	Тавилга	10,170,000.00	10,170,000.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	16,060,300.00	16,031,900.00	28,400.00	99.8
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	325,800.00	210,000.00	115,800.00	64.5
210702	Дотоод албан томилолт	325,800.00	210,000.00	115,800.00	64.5
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,735,000.00	1,669,000.00	66,000.00	96.2
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,135,000.00	1,069,000.00	66,000.00	94.2
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	600,000.00	0.00	100.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	5192300.00	5192300.00	0.00	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,192,300.00	5,192,300.00	0.00	100.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	32071400.00	30921300.00	1,150,100.00	96.4
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	32,071,400.00	30,921,300.00	1,150,100.00	96.4
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	31,921,400.00	30,921,300.00	1,000,100.00	96.9
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	150,000.00	00.00	150,000.00	0.0
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	1,230,695,100.00	1,210,974,771.00	19,720,329.00	98.4
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	1,003,469,900.00	990,937,413.00	12,532,487.00	98.8

Хөвсгөл аймгийн Түнэл сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,003,469,900.00	1,003,469,900.00	0.00	100.0
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	227,225,200.00	220,037,358.00	7,187,842.00	96.8
132001	Орон нутгийн төсвөөс	227,225,200.00	227,225,200.00	0.00	100.0
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	64	64	0.00	100.0
620001	Удирдах ажилтан	1	1	0.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	38	38	0.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	25	25	0.00	100.0
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>64</b>	<b>64</b>	0.00	100.0
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	37	37	0.00	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	27	27	0.00	100.0

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

		/төгрөгөөр/
Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>12,848,592.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>12,848,592.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	12,848,592.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	6,275,454.00
210401	Бичиг хэрэг	342,554.00
210402	Тээвэр, шатахуун	1,329,500.00
210404	Ном, хэвлэл	4,603,400.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	356,638.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	356,638.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2,823,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,785,000.00
210604	Урсгал засвар	1,038,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,518,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,518,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	1875500.00

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,875,500.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	12848592.55
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	12,848,592.55
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,288,592.55
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	560,000.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Монгол Улсын Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Түнэл сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээд болох Түнэл сумын ерөнхий боловсролын сургуульд нягтлан бодох бүртгэл, Шилэн дансны тухай хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой өгсөн албан шаардлагыг тусгасан болно.

Аудитыг хараат бус аудитын Ньюбаланс Аудит ХХК-ийн ахлах аудитор Б. Лхагвадорж, аудиторын туслах Т. Мөнхгэрэл нар гүйцэтгэж, хяналтыг Ньюбаланс Аудит ХХК-ийн аудитын чанарын хяналтын менежер Д. Гэрэлчулуун, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д. Отгонбаяр, аудитын менежер Э. Бат-Эрдэнэ, дарга, тэргүүлэх аудитор А. Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Түнэл сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ньюбаланс Аудит ХХК –д 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 02 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Түнэл сумын ерөнхий боловсролын сургууль нь хамран сургалтын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, хүүхдийн хөгжил оролцоог дээшлүүлэх, амьдрах чадвартай “Зөв хүүхэд” төлөвшүүлэх, боловсон хүчний нөөц, чадавхийг чанаржуулах, хүүхдэд ээлтэй орчныг бүрдүүлсэн хамт олон байх зорилго дэвшүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үндсэн үйл ажиллагаа, санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого, чиглэлд зарчмын өөрчлөлт ороогүй.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна. Тус байгууллагын мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын

баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажил байхгүй тул түүнийг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй бөгөөд боломжгүй юм.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Түнэл сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлсөн боловч, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгээгүй, хүлээн зөвшөөрөхүйц бус санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов. Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,293.8 сая төгрөгөөс 2 хувиар буюу 25.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 19.4 сая төгрөгөөр тогтоосон. Төлөвлөлтийн үе шатанд тогтоосон материаллаг байдлын түвшинг аудитын гүйцэтгэлийн үе шатанд шинэчлэн тогтоосон болно.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Түнэл сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,784.4 сая төгрөгөөр буюу 65.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна. (Хүснэгт 1-ээс үзнэ үү.)

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	2.6	0.0	-2.6
Бараа материал	128.9	157.9	28.9
Биет хөрөнгө	765.8	2,523.8	1,758.1
Биет бус хөрөнгө	36.7	36.6	-0.05
<b>Нийт хөрөнгө</b>	<b>933.9</b>	<b>2,718.3</b>	<b>1,784.4</b>
Хуримтлагдсан үр дүн	-263.8	1,525.5	1,789.3
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>933.9</b>	<b>2,718.3</b>	<b>1,784.4</b>

Бараа материалын дансны үлдэгдэл 157.9 сая төгрөг болж, 28.9 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд эм боох материал, аж ахуйн материал, барилгын материал, хүнсний материал зэрэг бараа авсан нь үлдэгдэл өсөхөд нөлөөлжээ. Тайлант хугацаанд 0.5 сая төгрөгийн аж ахуйн материал дансны хөрөнгийг актаар хассан байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 2,560.4 сая төгрөг болж, 1,758.0 сая төгрөгөөр өссөн нь шинээр дотуур байрны барилга ашиглалтад орсон, цахим сургалтын тоног төхөөрөмж худалдан авсан зэргээс үүдэлтэй байна. Үндсэн хөрөнгийн данс нь урсгал төсвөөс худалдан авалтаар 30.7 сая төгрөг, үнэ төлбөргүй шилжиж ирсэн барилга 1,797.4 сая төгрөг, 32.4 сая төгрөгийн дотуур байрны гал тогооны тоног төхөөрөмж, тавилга

хэрэгсэл, цахим сургалтын техник хэрэгсэл, зөөврийн компьютер хөрөнгөөр нэмэгдэж, Хөвсгөл аймгийн Түнэл сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн “Хөрөнгө актлах тухай” 40 дүгээр тогтоолоор 21.2 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл, Хөвсгөл аймгийн Түнэл сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн “Хөрөнгө актлах тухай” 50 дугаар тогтоолыг үндэслэн 8.8 сая төгрөгийн сургалтын агуулгаас хоцрогдсон сурах бичгийг данснаас хассан.

Биет бус хөрөнгөд бүртгэлтэй нягтлан бодох бүртгэлийн программыг 2009 онд, няравын бүртгэлийн программыг 2014 онд тус тус бүртгэн авсан ба 4 жилээр элэгдэл байгуулан ашигласан боловч одоо үлдэгдэл өртөг нь 0.2 сая төгрөг байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 2,718.3 сая төгрөг болж, 1,784.4 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн, хуримтлагдсан үр дүнд нөлөөлсөн.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь улсын төсвөөс санхүүжих тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт 46.9 сая төгрөгөөр буурсан, орон нутгийн төсвөөс санхүүжих санхүүжилт 55.5 сая төгрөгөөр, нэмэлт санхүүжилт 10.5 сая төгрөгөөр, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 29.4 сая төгрөгөөр тус тус өссөнтэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 1.3 сая төгрөгөөр буюу 0.11 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 12.9 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал болон нормативт зардал 41.6 сая төгрөгөөр тус тус өсч, төвлөрүүлэх шилжүүлэг 85.6 сая төгрөгөөр буурч өөрчлөгдсөн зардлууд байна.

Эдгээр нь 2021 онд шинээр дотуур байрны барилга ашиглалтад орсон, дотуур байранд амьдрах нэг хүүхдийн хоногийн хоолны зардлыг нэмэгдүүлсэн, короновируст халдварын цар тахлын улмаас ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагаа тодорхой хугацаанд цахим хэлбэрт шилжсэн, дотуур байранд амьдрах нэг хүүхдийн хоногийн хоолны зардлыг нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Түнэл сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,581.6 сая төгрөгөөр, нийт зарлагыг 1,581.6 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 350.9 сая төгрөгөөр бууруулан, 1,230.7 сая төгрөгийн төсөв баталжээ.

Тухайн төсвийн жилд төсөвт 2021 оны 7 дугаар сарын 7-ны өдөр батлагдсан Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн дагуу 1 удаа төсвийн тодотгол, эрх бүхий этгээдийн шийдвэрээр 2 удаа төсвийн зохицуулалт хийсэн. Тайлант жилийн онцгой нөхцөл байдлаас үүдэн хоол хүнсний зардал, хүүхдийн хоол хөтөлбөрийн зардлаас 14.1 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас 5.0 сая төгрөг, бусад тээвэр, шатахуун, томиллолт, зочны зардлаас шилжүүлэн, цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн дутагдсан зардалд 22.8 сая төгрөгийг зарцуулсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Түнэл сумын ерөнхий боловсролын сургууль тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,230.7 сая төгрөгийн төсөв баталснаас 1,230.7 сая төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,003.5 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 227.2 сая төгрөгийн санхүүжилт авч, нийт 1,230.7 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл

ажиллагаанд 1,211.0 сая төгрөгийг зарцуулж, 19.7 сая төгрөгийг улсын болон орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,211.0 сая төгрөг буюу 98.1 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлалын зардлыг 4.7 сая төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 4.7 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 7.2 сая төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 4.5 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлыг 2 хөтөлбөрийн 7 арга хэмжээнд 19.7 сая төгрөгөөр дутуу зарцуулсан байна.

71802 буюу ерөнхий боловсрол, 71806 буюу насан туршийн боловсрол хөтөлбөрийн хүрээнд 7 зориулалт, арга хэмжээнд зарцуулсан гүйцэтгэлийг хүснэгтээр үзүүлбэл :

Хүснэгт 2. Төсвийн хөтөлбөр, арга хэмжээний зарцуулалт

Хөтөлбөр	Зориулалт, арга хэмжээний код	Арга хэмжээний нэр	Төсөв	Гүйцэтгэл	зөрүү	Тайлбар
71802 Ерөнхий боловсрол	81834	Боловсролын стандарт сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	662.4	651.2	11.2	төвлөрүүлсэн
71806 Насан туршийн боловсрол	81834	Боловсролын стандарт сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	13.6	13.3	0.3	төвлөрүүлсэн
71802 Ерөнхий боловсрол	81835	Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	150.9	147.2	3.7	төвлөрүүлсэн
71802 Ерөнхий боловсрол	80109	Төсвийн шууд захирагчийн зардал	227.2	226.0	1.2	төвлөрүүлсэн
71802 Ерөнхий боловсрол	81801	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	31.9	30.9	1.0	төвлөрүүлсэн
71802 Ерөнхий боловсрол	81806				0.0	
71802 Ерөнхий боловсрол	81807	Хүүхдийн хоол	157.4	155.3	2.1	төвлөрүүлсэн
71802 Ерөнхий боловсрол	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж	0.2	0.0	0.2	төвлөрүүлсэн
	<b>Дүн</b>		<b>1,243.5</b>	<b>1,223.8</b>	<b>19.7</b>	

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна.” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Түнэл сумын ерөнхий боловсролын сургууль тайлант онд төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 0.5 сая төгрөг, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгийн орлого 12.3 сая төгрөгийн нэмэлт орлогыг бүрдүүлсэн. Уг хөрөнгийн эх үүсвэрээс ном, хэвлэлийн зардалд 4.6 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжид 1.5 сая төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 2.8 сая төгрөгийг тус тус зарцуулжээ. Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Түнэл сумын ерөнхий боловсролын сургууль нь 2021 онд улсын төсвийн хөрөнгийн эх үүсвэрээр баригдан ашиглалтад хүлээлгэн өгсөн шинэ дотуур байрны барилгыг гаднах тохижилтийн хамт үндсэн хөрөнгийн дансанд бүртгэн авсан ба хуучин дотуур байрны барилгыг “Үдийн хоол”-ны бэлтгэлийн байр болгож, түүний үйл ажиллагаанд шаардагдах гал тогооны тоног төхөөрөмжийг 19.1 сая төгрөгөөр, оны эцэст шууд худалдан авсан. Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 5 дугаар сарын 5-ны өдрийн “Босго үнэ шинэчлэн батлах тухай” 124 дүгээр тогтоолын хавсралт ёсоор баталсан шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаарт нийцэж байна. Иймд “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн дагуу төсвийн хөрөнгийн эх үүсвэрийг захиран зарцуулсан гэж дүгнэлээ.

Түүнчлэн Ковид-19 цар тахлын үеийн хариу арга хэмжээний хүрээнд цахим сургалтын үйл ажиллагаанд зориулсан компьютер, электрон самбар, телевизор, сургалтын зориулалттай ширээ, тавилгыг 11.7 сая төгрөгөөр худалдан авсан. Хөвсгөл аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн А/608 тоот захирамжийн 3 дугаар хавсралтаар баталсан төсвийн зохицуулалтын дагуу түлш халаалт, хоол, хүнс, үдийн хоол хөтөлбөрийн зардлын хэмнэлтээс 19.1 сая төгрөгийг зарцуулсан байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Санхүүгийн тайлангийн аудитын явцад дараах асуудал үүссэн болно. Үүнд:

Шалгагдагч байгууллагын 2021 оны санхүүгийн байдлын тайлан, бараа, материалын тайлангийн тодруулгын эцсийн үлдэгдэл зөрүүтэй тайлагнасан тул залруулах шаардлага үүссэн. Бараа материалын дансны үлдэгдэлд үнэ төлбөргүй нийлүүлэгдсэн барааг тусгахдаа барааны нэр, дансны ангиллыг буруу сонгож тусгасан, уг барааны тооллогыг хийхдээ тухайн алдааг залруулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4, 13.5-д заасныг хэрэгжүүлээгүй байна. Дахин үнэлэгдэж орлого авсан хөрөнгийн санхүүгийн тайлангийн дүн болон Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 111 дугаар тогтоолын дүнгээс 0.08 сая төгрөгөөр зөрсөн учрыг тодруулж тайлбар авсан. Аж ахуйн материалын дансанд 0.7 сая төгрөгийн үнэ бүхий насос буюу үндсэн хөрөнгө бүртгэсэн. Мөн уг дансны тооллого хийж, үлдэгдэлд бүртгэл хийгдснийг илрүүлсэн. Дансны ангилал буруу бүртгэсэн тул үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоогүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.6-д заасны дагуу бүртгэл хөтлөөгүй байна.

Санхүүгийн аудитын төлөвлөлтийн үе шатанд байгууллагын дотоод хяналтын талаар ойлголт олж авах явцад тодорхойлсон эрсдэл болох “Үндсэн хөрөнгийн хадгалалт, хамгаалалт сул байх” эрсдэлд хариу өгөх нарийвчилсан сорил хэрэгжүүлэхэд 19.2 сая төгрөгийн элэгдлийг 1,761.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгөд тооцоогүй орхигдуулсан нь мөн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.6-д заасныг зөрчсөн.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал байхгүй болно.

### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Төсвийн шууд захирагч нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг Засгийн газрын 2016 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-д зааснаар, хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай. Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудас болох [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) - д ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгасан.

Тайлант хугацаанд мэдээлбэл зохих 10 төрлийн мэдээллээс хугацаа хоцроосон 1, мэдээлээгүй 7 төрлийн мэдээлэл байна. Мэдээлбэл зохих 65 мэдээллээс 35 мэдээлэл мэдээлээгүй 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Шилэн дансанд мэдээллийг байршуулахдаа мэдээллийн үнэн зөв байдлыг нягтлахгүй байна. 2021 оны 3 дугаар улирлын төсвийн гүйцэтгэлийн мэдээг мэдээлэхдээ сумын Төрийн санд хянагдан баталгаажсан сарын мэдээнээс 148.9 сая төгрөгийн зөрүүтэй мэдээлсэн. Иймд дээрх зөрчлийг таслан зогсоох, дахин давтахгүй байх хугацаатай албан шаардлага өгч ажиллав.

### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

- Монгол Улсын Засгийн газрын “Үдийн хоолны норматив тогтоох тухай” 2021 оны 8 дугаар сарын 11-ний өдрийн 237 дугаар тогтоолын 1-д “Ерөнхий боловсролын сургуулийн 1-5 дугаар ангийн нэг хүүхдэд ногдох үдийн хоолны зардлын нормативыг 2021 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс 1500 (нэг мянга таван зуун) төгрөгөөр тогтоосугай.” гэж, 2-д “...6-9 дүгээр ангийн нэг хүүхдэд ногдох үдийн хоолны зардлын нормативыг 2022 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс 1800 (нэг мянга найман зуун) төгрөг байхаар тогтоож...” гэж тус тус заасныг мөрдөн ажилласан байна. Мөн Засгийн газрын “Хоолны зардлын норматив тогтоох тухай” 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 450 дугаар тогтоолын 2-т “Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байранд амьдрах нэг хүүхдийн хоногийн хоолны зардлыг 3475 (Гурван мянга дөрвөн зуун далан таван) төгрөгөөр тогтоосугай.” гэж заасныг дагаж мөрдөж байна. 2021 онд хоолны зардлаас 14.1 сая төгрөгийг хэмнэсэн боловч эрх бүхий этгээдийн шийдвэрээр төсвийн зохицуулалт хийлгэсэн.
- Тайлант хугацаанд “Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль”-ийн 1 дүгээр зүйл, “Нийгмийн даатгалын тухай хууль”-ийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ болох “12.7” хувьд өөрчлөлт орж, “11.7” хувь, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ болох “12.5” хувьд өөрчлөлт орж, “11.5” хувь болж өөрчлөгдсөн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Тус сургуулийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 1,811.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 1,811.5 сая төгрөгийн алдааг залруулж, 0.3 сая

төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгсөн боловч аудитаар дахин хянахад Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтыг үндэслэн дансны бүртгэл, бичилт хийхдээ данс буруу ангилах, бүртгэх, баримт бичгийн баталгаажуулалт, хадгалалт, хамгаалалт, архивлалт, байгууллагын дотоод хяналтын зохион байгуулалтын үр нөлөө, санхүүгийн ажилтны мэргэжлийн ур чадварт анхаарах шаардлагатай гэж үзэв.

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 20.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 19.2 сая төгрөгийн алдааг залруулж, 1.0 сая төгрөгийн зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлж байна.

### **4.1 Залруулсан алдаа**

Аудитаар илэрсэн нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой 19.2 сая төгрөгийн алдааг аудитын хугацаанд залруулан ажиллав. Үүнд: Хөвсгөл аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн 71 дүгээр тогтоолыг үндэслэн 2021 оны 7 дугаар сарын 5-ны өдөр орлого авсан 1,761. 5 сая төгрөгийн сургуулийн дотуур байрны барилга, цементэн талбай, худгийн байшин тус бүрд үндсэн хөрөнгийн элэгдэл 19.2 сая төгрөгийг тооцож, холбогдох дансны бичилтийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу хийн, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1.-д заасан санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүнгийн тайланд тусгав.

Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 0.8 сая төгрөгийн алдааг залруулаагүй бөгөөд уг алдаа нь нягтлан бодох бүртгэлийн давхар бичилт, анхан шатны бүртгэл, тайлагналын олон, дамжсан бичилтүүдтэй холбоотой тул албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн болно.

### **4.2 Төлбөрийн акт**

Төлбөрийн акт тогтоогоогүй болно.

### **4.3 Албан шаардлага**

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.” гэж заасныг үндэслэн дараах зөрчилд албан шардлага өгсөн болно.

1 Түнэл сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх явцад эм боох материалын дансанд барааг анхан шатны баримт дахь нэрийг зөрүүлэн орлого авсан (санитолыг номын сангийн сандал), бараа материалын тооллогын бүртгэлд дахин буруу нэрээр нь бүртгэж, тоолсон, халуун хэмжигчийг акталж, устгасан эрх бүхий этгээдийн шийдвэргүйгээр зарлага болгосон, бараа материалын шаардах хуудас, зарлагын баримтад нягтлан бодогч хянаж, баталгаажуулан гарын үсэг зураагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.” гэснийг, 13.4-д “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна.” гэснийг, 13.5-д “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж,

тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна.” гэснийг, 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.” гэснийг, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” гэснийг тус тус зөрчсөн;

2. Аж ахуйн материалын дансанд 750 000.00 төгрөгийн үнэ бүхий насос буюу үндсэн хөрөнгийг орлого авч бүртгэсэн, бараа материалын тооллогын бүртгэлд залруулахгүй тусгаж, тоолсон, дансны ангилал буруу бүртгэсэн учир үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоогүй, санхүүгийн тайланд буруу илэрхийлэгдсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх,” гэж заасныг баримтлаагүй, мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах,” гэж заасныг биелүүлээгүй зөрчсөн;

3. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг Засгийн газрын 2016 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын дагуу Шилэн дансны нэгдсэн цахим хуудас болох [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) -д ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгахад мэдээллийг бүрэн, үнэн зөв мэдээлээгүй, 10.2 сая төгрөгийн 1 мэдээллийг байршуулаагүй, 2021 оны 3 дугаар улирлын төсвийн гүйцэтгэлийн сумын Төрийн санд хянагдсан хэвлэмэл мэдээг 148.9 сая төгрөгийн зөрүүтэй мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан зарчмыг баримталж, хуулийг хэрэгжүүлээгүй, Шилэн дансны тухай хууль, журам болон Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д “Иргэн, хуулийн этгээд нь хүний эрх, эрх чөлөө, үндэсний аюулгүй байдал, байгууллагын хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор хууль тогтоомжид нийтэд мэдээлэхийг хориглосноос бусад дараах мэдээллийг энэ хуулийн 3.1-д заасан байгууллагаас авах эрхтэй:” гэж заасныг зөрчсөн, өмнөх жилийн санхүүгийн аудитаар өгсөн шилэн данстай холбоотой зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй;

#### **4.4 Зөвлөмж**

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй тул албан шаардлага өгсөн болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### **5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

Хөвсгөл аймгийн Түнэл сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

с. Аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй төлөг

/сая төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Хөвсгөл аймгийн Түнэл сумын ерөнхий боловсролын сургууль	4	1,230.1	2	19.2			2	1,210.9		
	<b>Нийт</b>	<b>4</b>	<b>1,230.1</b>	<b>2</b>	<b>19.2</b>			<b>2</b>	<b>1,210.9</b>		

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРААС

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

АУДИТЫН МЕНЕЖЕР:

АХЛАХ АУДИТОР

А. ЭРДЭНЭБААТАР  
Огноо:

Э. БАТ-ЭРДЭНЭ  
Огноо:

Д. ОТГОНБЯАР  
Огноо:

НЬЮБАЛАНС АУДИТ ХХК-ИАС

ХЯНАСАН:

ЗАХИРАЛ

ХЯНАСАН:

ЧАНАРЫН ХЯНАЛТЫН МЕНЕЖЕР

БОЛОВСРУУЛСАН:  
АУДИТОРЫН ТУСЛАХ

Б. ЛХАГВАДОРЖ  
Огноо:

Д. ГЭРЭЛЧУЛУУН

Т. МӨНХГЭРЭЛ  
Огноо:



## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 сарын 17 өдөр

№ 38/АЭЭӨ0434/ХӨА-2022/  
92/ХА-СТА-ТШЗ

Мөрөн сум

### Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д болон 8 дугаар зүйлийн 8.1, 8.4-т заасныг үндэслэн Хөвсгөл аймгийн Түнэл сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Үүнд: Бараа материал, үндсэн хөрөнгө дансыг үнэн зөв ангилаагүй, барааны нэрийг нягтлан бодох бүртгэл, тооллогын бүртгэлд зөрүүтэй бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" заалттай нийцэхгүй, толилуулга ба тодруулга, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө." Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаал "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заасныг үндэслэн ШААРДАХ нь:

1. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, журамд заасны дагуу нягтлан бодох бүртгэлийг үнэн зөв хөтөлж, дээрх зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 8 дугаар сарын 19-ний өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг мэдэгдье.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гарахгүй ажиллах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Түнэл сумын ерөнхий боловсролын сургуулийн захирал Ж.Баярмаа, нягтлан бодогч Г. Жадамбаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮДЭХ АУДИТОР

А. ЭРДЭНЭБААТАР

НЬЮБАЛАНС АУДИТ ХХК АУДИТОР

Б.ЛХАГВАДОРЖ

<sup>1</sup> Монгол Улс, Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, Хөвсгөл аймгийн ЗДТГ-ын байр 3 давхар 302 тоот



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 сарын 17 өдөр

№ 39/А.2260434/ХӨА-2022/  
92/НА-СТА-ТШЗ

Мөрөн сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хөвсгөл аймгийн Түнэл сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:


Шилэн дансанд 2021 оны хагас жилийн санхүүгийн тайлан, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, дараа жилийн төсвийн төсөл, 10.2 сая төгрөгийн 1 мэдээллийг байршуулаагүй, төсвийн гүйцэтгэлийн 2021 оны 3 дугаар улирлын мэдээг 148.9 сая төгрөгийн зөрүүтэй мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 6.4-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө." Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаал "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлээгүй 2021 оны хагас жилийн санхүүгийн тайлан, худалдан авалтын төлөвлөгөө, тайлан, дараа жилийн төсвийн төсөл, 10.2 сая төгрөгийн 1 мэдээлэл, 2021 оны 3 дугаар улирлын төсвийн гүйцэтгэлийн мэдээг 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн shilendans.gov.mn сайтад байршуулж, биелэлтийг 2022 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар<sup>1</sup>т ирүүлэх,
2. Цаашид Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангуулж ажиллахыг Түнэл сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал Ж.Баярмаа, нягтлан бодогч Г. Жадамбаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  А.ЭРДЭНЭБААТАР

"НЬЮБАЛАНС АУДИТ" ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ  Б.ЛХАГВАДОРЖ

<sup>1</sup> Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8 дугаар баг, аймгийн ЗДТГ-ын байрны А корпус 3 давхар 303 тоот, утасны дугаар: 7038 4043

## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Хөвсгөл аймгийн Түнэл сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ХӨА-2022/92/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Хөвсгөл аймаг Мөрөн сум 2022 он</p>	<p>Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: А. Эрдэнэбаатар Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatar@audit.gov.mn Аудитын менежер: Э. Бат-Эрдэнэ Утас: 99900662, Цахим хаяг: Baterdenee@audit.gov.mn Ахлах аудитор: Д. Отгонбаяр Утас: 89306788, Цахим хаяг: otgonbayarde@audit.gov.mn Ньюбаланс Аудит ХХК-ийн захирал Б. Лхагвадорж Утас: 99101901, Цахим хаяг: newbalance.lhagvaa@gmail.com Чанарын хяналтын менежер Д. Гэрэлчулуун Утас: 99509636.Цахим хаяг: d.gerlee98@gmail.com Аудиторын туслах: Т. Мөнхгэрэл Холбогдох утас: 99011389 Цахим хаяг: tumurmunkh08@gmail.com</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ТҮНЭЛ СУМЫН  
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН  
ЗАХИРАЛ Ж. БАЯРМАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, 8.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Түнэл сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Түнэл сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч нь санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв, иж бүрэн бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А. ЭРДЭНЭБААТАР

### Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/сая төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
<b>Санхүүгийн байдлын тайлан</b>			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	131.5	157.9
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	802.4	2,560.4
	<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>933.9</b>	<b>2,718.3</b>
	Нийт өр төлбөрийн дүн	0	0
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	<b>933.9</b>	<b>2,718.3</b>
	<b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>933.9</b>	<b>2,718.3</b>
<b>Санхүүгийн үр дүнгийн тайлан</b>			
	Үйл ажиллагааны орлогын дүн	3,032.6	3,083.4
	Үйл ажиллагааны зардлын дүн	1,295.2	1,296.5
	<b>Үйл ажиллагааны үр дүн</b>	<b>1,737.4</b>	<b>1,787.0</b>
	Үйл ажиллагааны бус үр дүн		
	<b>Үйл ажиллагааны нийт үр дүн</b>	<b>1,737.4</b>	<b>1,787.0</b>
<b>Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан</b>			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0	0
	Тайлант оны үр дүн	<b>-184.9</b>	<b>1,786.9</b>
	<b>Эцсийн үлдэгдэл</b>	<b>933.9</b>	<b>2,718.3</b>
<b>Мөнгөн гүйлгээний тайлан</b>			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	<b>1,222.1</b>	<b>1,243.5</b>
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	<b>1,213.3</b>	<b>1,212.5</b>
	<b>Үйл ажиллагааны ЦМГ</b>	<b>8.9</b>	<b>31.0</b>
	<b>Хөрөнгө оруулалтын ЦМГ</b>	<b>8.2</b>	<b>31.0</b>
	<b>Санхүүгийн ажиллагааны ЦМГ</b>	<b>0</b>	<b>0</b>
	<b>Нийт цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>0.6</b>	<b>0</b>
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>Төсвийн гүйцэтгэлийн тайлан</b>			
	<b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>	<b>1,234.1</b>	<b>1,211.0</b>
	Урсгал зардал	1,234.1	1,211.0
	Хөрөнгийн зардал	00.00	00.00
	<b>Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр</b>	<b>1,230.7</b>	<b>1,230.7</b>
	Улсын төсвөөс санхүүжих	1,003.5	1,003.5
	Орон нутгийн төсвөөс	227.2	227.2

### Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Түнэл сумын ерөнхий боловсролын сургууль нь хамран сургалтын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, хүүхдийн хөгжил оролцоог дээшлүүлэх, амьдрах чадвартай “Зөв хүүхэд” төлөвшүүлэх, боловсон хүчний нөөц, чадавхийг чанаржуулах, хүүхдэд ээлтэй орчныг бүрдүүлсэн хамт олон байх зорилго дэвшүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үндсэн үйл ажиллагаа, санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого, чиглэлд зарчмын өөрчлөлт ороогүй.

## **Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Түнэл сумын ерөнхий боловсролын сургууль нь 2021 онд улсын төсвийн хөрөнгийн эх үүсвэрээр баригдан ашиглалтад хүлээлгэн өгсөн шинэ дотуур байрны барилгыг гаднах тохижилтийн хамт үндсэн хөрөнгийн дансанд бүртгэн авсан ба хуучин дотуур байрны барилгыг “Үдийн хоол”-ны бэлтгэлийн байр болгож, түүний үйл ажиллагаанд шаардагдах гал тогооны тоног төхөөрөмжийг 19.1 сая төгрөгөөр, оны эцэст шууд худалдан авсан. Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 5 дугаар сарын 5-ны өдрийн “Босго үнэ шинэчлэн батлах тухай” 124 дүгээр тогтоолын хавсралт ёсоор баталсан шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаарт нийцэж байна. Иймд “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн дагуу төсвийн хөрөнгийн эх үүсвэрийг захиран зарцуулсан гэж дүгнэлээ.

Түүнчлэн Ковид-19 цар тахлын үеийн хариу арга хэмжээний хүрээнд цахим сургалтын үйл ажиллагаанд зориулсан компьютер, электрон самбар, телевизор, сургалтын зориулалттай ширээ, тавилгыг 11.7 сая төгрөгөөр худалдан авсан. Хөвсгөл аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн А/608 тоот захирамжийн 3 дугаар хавсралтын дагуу төсвийн зохицуулалт хийж, түлш халаалт, хоол, хүнс, үдийн хоол хөтөлбөрийн зардлын хэмнэлтээс 19.1 сая төгрөгийг зарцуулсан байна.

## **Дөрөв. Аудитын гол асуудал**

Санхүүгийн тайлангийн аудитын явцад дараах асуудал үүссэн болно. Үүнд:

Шалгагдагч байгууллагын 2021 оны санхүүгийн байдлын тайлан, бараа, материалын тайлангийн тодруулгын эцсийн үлдэгдэл зөрүүтэй тайлагнасан тул залруулах шаардлага үүссэн. Бараа материалын дансны үлдэгдэлд үнэ төлбөргүй нийлүүлэгдсэн барааг тусгахдаа барааны нэр, дансны ангиллыг буруу сонгож тусгасан, уг барааны тооллогыг хийхдээ тухайн алдааг залруулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4, 13.5-д заасныг хэрэгжүүлээгүй байна. Дахин үнэлэгдэж орлого авсан хөрөнгийн санхүүгийн тайлангийн дүн болон Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 111 дугаар тогтоолын дүнгээс 0.08 сая төгрөгөөр зөрсөн учрыг тодруулж тайлбар авсан. Аж ахуйн материалын дансанд 0.7 сая төгрөгийн үнэ бүхий насос буюу үндсэн хөрөнгө бүртгэсэн. Мөн уг дансны тооллого хийж, үлдэгдэлд бүртгэл хийгдснийг илрүүлсэн. Дансны ангилал буруу бүртгэсэн тул үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоогүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.6-д заасны дагуу бүртгэл хөтлөөгүй байна.

Санхүүгийн аудитын төлөвлөлтийн үе шатанд байгууллагын дотоод хяналтын талаар ойлголт олж авах явцад тодорхойлсон эрсдэл болох “Үндсэн хөрөнгийн хадгалалт, хамгаалалт сул байх” эрсдэлд хариу өгөх нарийвчилсан сорил хэрэгжүүлэхэд 19.2 сая төгрөгийн элэгдлийг 1,761.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгөд тооцоогүй орхигдуулсан нь мөн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.6-д заасныг зөрчсөн.

## **Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал байхгүй болно.

## **Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтыг үндэслэн дансны бүртгэл, бичилт хийхдээ данс буруу ангилах, бүртгэх, баримт бичгийн баталгаажуулалт, хадгалалт, хамгаалалт, архивлалт, байгууллагын дотоод хяналтын зохион байгуулалтын үр нөлөө, санхүүгийн ажилтны мэргэжлийн ур чадварт анхаарах шаардлагатай гэж үзэв.

### Долоо. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 20.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 19.2 сая төгрөгийн алдааг залруулж, 1.0 сая төгрөгийн алдааг залруулах албан шаардлага, Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой зөрчлийг таслан зогсоох албан шаардлагыг тус тус хүргүүлж байна.

### 7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			

### 7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Хөвсгөл аймгийн Түнэл сумын ерөнхий боловсролын сургууль	4		2				2			
	<b>Нийт</b>	<b>4</b>		<b>2</b>				<b>2</b>			

